



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/НБ

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а, г", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа явуулах "АНЭС ФАРМ" ХХК-ний эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр шинээр олгосугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Арга билэг" үүдэн эмнэлэг, "Байгаль" эмийн сан, Дадал суманд үйл ажиллагаа явуулж буй "Уужим тал" эмийн сан, Бэрх суманд үйл ажиллагаа явуулж буй "Номгон" ХХКомпаний эмийн эргэлтийн сан, Хэрлэн баян Улаан тосгоны Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилээр сунгасугай.

3. Дээрх эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баасандорж/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц ИДЭРБАТ

231010580